



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/02/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Баруун-Урт сум 2022 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: М.Нарантуяа Утас: 70518396</p> <p>Аудитын менежер: Г.Даваа Утас: 70512123</p> <p>Аудитор: Б.Ариунзул Утас: 70512127</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
3. Аудитын тайлан.....	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал.....	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
Байгууллагын үйл ажилагаа	10
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	10
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	12
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
4.2.2 Зөвлөмж.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.03.16 № 138

танай _____-ны № _____-г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дарьганга тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	35942663.28	21998344.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	10174654.27	301409.29
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	10174654.27	301409.29
3121	Төгрөг	10174654.27	301409.29
31213	Арилжааны банк дахь харилцах	10,174,654.27	301,409.29
33	АВЛАГА	9,117,080.01	12,200,481.84
33400	Зээлийн хүүгийн авлага	9,117,080.01	11,829,236.18
33401	Дансны авлага /ТӨҮГ/	9,117,080.01	11,829,236.18
33402	Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/	00.00	371,245.66
35	БАРАА МАТЕРИАЛ	16,650,929.00	9,496,453.00
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	100,000.00	100,000.00
354	Хангамжийн материал	16550929.00	9396453.00
35410	Бичиг хэргийн материал	19,440.00	64,440.00
35420	Аж ахуйн материал	12,614,030.00	5,359,030.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,920,000.00	2,398,000.00
35440	Түлш, шатах тослох материал	542,983.00	542,983.00
35450	Барилгын засварын материал	454,476.00	1,032,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	853714735.06	776417354.58
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	853,714,735.06	776,417,354.58
392	Биет хөрөнгө	848830076.72	771725196.25
39201	Барилга, байгууламж, орон сууц	942,988,171.00	942,988,171.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-121,911,427.61	-182,867,141.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	92,600,000.00	18,175,000.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,846,666.67	-6,570,833.33
393	Биет бус хөрөнгө	4884658.33	4692158.33
39301	Програм хангамж	5,093,200.00	5,093,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-208,541.67	-401,041.67
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	889657398.34	798415698.71
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	915782329.90	794906358.43
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	915782329.90	794906358.43
413	Өглөг	83,971,961.51	34,864,203.85
4136	Бусад өглөг	83971961.51	34864203.85
41363	Татварын өглөг /ТӨҮГ/	5,432,990.51	2,733,595.85
41366	Дансны өглөг /ТӨҮГ/	78,538,971.00	32,130,608.00
414	Урьдчилж орсон орлого	831810368.39	760042154.58
41440	Бусад урьдчилж орсон орлого	831,810,368.39	760,042,154.58
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-26124931.56	3509340.28
51	Засгийн газрын хувь оролцоо	-26,124,931.56	3,509,340.28
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	00.00	2,075,000.00
51101	Өмч: - төрийн	00.00	2,075,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	-26,124,931.56	1,434,340.28
51210	Өмнөх үеийн үр дүн	-26,124,931.56	-28,199,931.56
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	29,634,271.84

6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>889657398.34</u>	<u>798415698.71</u>
---	---	---------------------	---------------------

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
120	Нийтлэг татварын бус орлого	244127491.28	265434401.05
120009	Бусад орлого	13,883,512.88	18,138,217.48
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	230,243,978.40	247,296,183.57
120011	Борлуулалтын өртөг /ТӨҮГ/	189946362.26	169071341.52
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	46029226.00	54787510.21
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46029226.00	54787510.21
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	46,029,226.00	54,787,510.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30370465.00	37562517.00
210101	Үндсэн цалин	30,370,465.00	37,562,517.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3194802.71	4494304.08
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	3,194,802.71	4,494,304.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	397600.00	255645.87
210301	Гэрэл, цахилгаан	00.00	105,645.87
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	397,600.00	150,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2320608.29	5277976.60
210401	Бичиг хэрэг	414,511.29	392,026.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	175,000.00	300,000.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	1,731,097.00	2,001,150.00
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	00.00	2,584,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	40000.00
210604	Урсгал засвар	00.00	40,000.00
2107	Томилолт, зочны зардал	509000.00	1204000.00
210702	Дотоод албан томилолт	509,000.00	1,204,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3700750.00	0.00
210812	Санхүүгийн зардал /ТӨҮГ/	1025750.00	
210813	Бусад зардал /ТӨҮГ/	2675000.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5536000.00	5953066.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,536,000.00	4,848,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	1,104,166.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8151903.02	41575549.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	10000000.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	10,000,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	-10000000.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8151903.02	31575549.32

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл		0.00	-28,199,931.56	0.00	- 28,199,931.56
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	2,075,000.00	00.00	00.00	00.00	2,075,000.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	29,634,271.84	00.00	29,634,271.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,075,000.00	0.00	1,434,340.28	0.00	3,509,340.28

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	280352029.15	293700101.24
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280352029.15	293700101.24
120	Нийтлэг татварын бус орлого	280352029.15	293700101.24
120009	Бусад орлого	14,184,495.15	15,980,944.75
120013	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого /ТӨҮГ/	266,167,534.00	277,719,156.49
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	270639517.14	303573346.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	270639517.14	303573346.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	270639517.14	303573346.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	53351423.00	62032012.07
210106	Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/	53,351,423.00	62,032,012.07
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14472329.35	16976139.54
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	14,472,329.35	16,976,139.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15871539.53	13809680.88
210305	Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/	15,871,539.53	13,809,680.88
2104	Хангамж, бараа материалын зардал	168224049.00	163593815.70
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	87,298,476.00	55,572,713.60
210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	80,925,573.00	108,021,102.10
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18720176.26	47161698.03
210816	Татварын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	9,648,876.26	27,601,814.03
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/	9,071,300.00	19,559,884.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	9712512.01	-9873244.98
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	9712512.01	-9873244.98
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	462,142.26	10,174,654.27
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10,174,654.27	301,409.29

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад үндсэн хөрөнгө, өр төлбөр, авлагатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунзул гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 1/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ нь “Дарьганга сумын ААНБ, айл өрхийг дулаанаар тасралтгүй найдвартай хангаж цаашид сумынхаа айл өрх ААН-ийг дулаанд холбож, иргэдээ дулаан тав тухтай нөхцөлийг хангах, байгаль орчны эрүүл, цэвэр үзэмжтэй байдлыг бий болгосон байгууллага болно ” зорилго дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Тус байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 303.5 сая төгрөгөөс 2 хувиар буюу 6.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга Байгууллагын үйл ажилагаа

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Дарьганга Тохижилт аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын статустай байна. Өмчийн 100 хувийг орон нутгийн өмчлөлд эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дарьганга Тохижилт ОНӨААТҮГ-н дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Тухайн сумын төсвийн албан газрууд, ААН, айл өрхөд дулаан түгээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж аль болох ашигтай ажиллана.
- Орон нутгийн төр захиргааны байгууллагаас баталсан төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн хэмжээнд тодорхой төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлнэ.
- Иргэд ард түмний санал бодлыг сонсож ажил хэрэг болгох тал дээр анхаарч ажиллана.
- Түүхэн үйл явдлын ой тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавъяат үйлстнийг алдаршуулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулахад оролцоно.
- “Дарьганга тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-н үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэж цаашид авах арга хэмжээг авч ажиллана.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөөгүй боловч чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоогоор 13 албан хаагчтай үйл ажиллагаагаа явуулахаас 13 орон тоотой явуулсан, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан 0.7 сая төгрөгөөр тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дарьганга Тохижилт ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10.1	0.3	-9.8
Авлага	9.1	11.8	2.7
Бараа материал	16.6	9.4	7.2
Үндсэн хөрөнгө	848.8	771.7	77.1
Нийт хөрөнгийн дүн	889.6	798.4	91.2
Өр төлбөрийн дүн	78.5	32.1	-46.4
Эздийн өмч	-26.1	29.6	3.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	889.6	798.4	91.2

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Харилцах дансны эхний үлдэгдэлд 10.1 сая, эцсийн үлдэгдэл 0.3 сая төгрөг байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 32.1 сая төгрөг болж 46.4 сая буюу 58 хувиар буурсан байна. Энэ нь тайланд онд ашигтай ажилласан, 2020 оны эцсээр Засгийн газраас авах авлага авч, мөн Ковш 14.0 сая төгрөгөөр зарсан зэрэг нь өмнөх оны өр төлбөр буурахад нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдэлд 11.8 сая төгрөг болж 2.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Мөн 848.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй үндсэн хөрөнгө данс нь тайлант онд 77.1 сая төгрөгөөр буурсан байна.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “к”-д заасны дагуу Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТҮГ-н захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө, ашиг орлогын хуваарилалтыг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Нийт орлого 2020 онтой харьцуулахад 2021 онд 13.4 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар нэмэгдсэн байна. Орлого нэмэгдсэн нь 2021 онд халаалтад 5 ААН-ийг шинээр холбуулж, 9 ААН, айл өрх өргөтөл хийснээр нэмж 1732,4м³ талбайг холбуулан, халаалтын гэрээг байгуулсантай холбоотой байна.

Гүйцэтгэлээр 265.4 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлж, 169.0 сая төгрөгийн борлуулалтын зардал гарган, үйл ажиллагааны орлого 96.3 сая, зардлын дүн 56.7 сая, үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз 10.0 сая төгрөг болж, 29.6 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал үүсээгүй.

3.8 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Дарьганга Тохижилт ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Гүйцэтгэлийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Зөвлөмж	1		1		100
Нийт дүн	1		1		100

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 30.6 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 3.6 сая төгрөгийн албан шаардлага, өр төлбөртэй холбоотой 27.0 сая төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлээ.

4.2.1 Албан шаардлага:

1.1 Илрүүлэлт:

Байгууллагын ажилтан цалингийн урьдчилгаа болох 3.6 сая төгрөгийн урьдчилгааг суутган тооцуулаагүй байгаа нь “эрх ба үүрэг”, “иж бүрэн”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.2.2 Зөвлөмж

1. Өр төлбөртэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллага “Олгой булаг” нүүрсний уурхайтай гэрээ байгуулан нүүрс авсан боловч 2017 оноос хойш 27.0 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулаагүй байгаа нь “эрх ба үүрэг”, “иж бүрэн”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2.1. Өгсөн зөвлөмж:

Байгууллагын үйл ажиллагааг зөв зохистой удирдаж, он дамжсан өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Дарьганга Тохижилт Үйлчилгээ ОНӨААТГ	2	30.6					1	3.6	1	27.0
Дүн		2	30.6					1	3.6	1	27.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
Дүн											
Нийт дүн											